



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1291

Мандалговь

Тэмцээнд оролцуулах тухай

Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах гэрээний 2.8, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын А/47 дугаар тушаал, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тушаалын "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3 дах заалт, Аймгийн засаг даргын 2017 оны 12 дугаар зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит ахлах ангийн сурагчдын дунд явагдах улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд баг тамирчид бэлтгэн 2017 оны 09 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд оролцуулсугай.

Хоёр. Тэмцээний бэлтгэл ажлыг удирдамжийн дагуу чанартай сайн бэлтгэж сургах, ажил мэргэжлийн талаар шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Б.Амаржаргал, Боловсрол Соёл урлагийн газрын дарга Ц.Бумангэрэл, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн захирагч дэд хурандаа Д.Ганболд, Биеийн тамир, спортын газрын дарга М.Наранбадрах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулахыг нэгдсэн эмнэлэгийн дарга Х.Жаргал нарт тус тус даалгасугай.

Гурав. Тэмцээнд оролцох, ирж буцах, бэлтгэл ажлийн хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллахыг цэргийн штабын ОНХ, сургалтын офицер хошууч Ш.Гансүх, дасгалжуулагч багш М.Энхтайван нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Нийт зардалд шаардагдах 2.395.380 /Хоёр сая гурван зуун ерэн таван мянга гурван зуун наян мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0300828